



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд сум дахь сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Л.Равдандорж Утас: 70523020 Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Дорног. 02.24 № 1-6/96

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД
СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ
ЦААЗЫН ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ
Д.ЭНХБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13.3	29.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	963.5	987.3
	Нийт хөрөнгийн дүн	976.8	1,017.0
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	10.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	976.8	1,007.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	976.8	1,017.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	345.3	503.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	333.0	473.4
	Үйл ажиллагааны үр дүн	12.3	30.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	12.3	30.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	958.9	976.8
	Тайлант оны үр дүн	12.3	30.2
	Эцсийн үлдэгдэл	976.8	1,007.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	332.1	482.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	312.1	446.3
	Үйл ажиллагааны ЦМГ	10.0	35.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	10.0	25.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	10.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	10.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	316.1	421.6
	Урсгал зардал	316.1	421.6
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	316.1	472.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	0.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго: Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, төрийн нэрийн өмнөөс хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох.

Зорилт:

1. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар шинээр батлагдсан заавар, журам, албан даалгаврын заалт бүрийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнд хүрсэн байна.
- Прокурор, ажилтнууд мэдлэг боловсрол, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллаж, хяналтын ажлын чанар үр дүнд мэдэгдэхүйц өөрчлөлтийг гаргасан байна.

Ялангуяа хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтын ажлыг шаардлагын түвшинд хүргэсэн байна.

3. Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төр, захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, хяналтын ажлын үр нөлөөг дээшлүүлж, тоо хэмжээг нэмэгдүүлэх

Замын-Үүд сум дахь сум дундын Прокурорын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавих
 2. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих
 3. Төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох
 4. Зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох
 5. Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох
 6. Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах
 7. Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих
- Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар онцлох асуудал илэрсэнгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Замын-Үүд сум дахь сум дундын Прокурорын газрын залруулагдаагүй нийт алдаа зөрчил нь 23.4 сая төгрөг буюу материаллаг хэмжээнээс 13.6 сая төгрөгөөр давсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээгээр голлох нөлөө үзүүлсэн дараах алдаа, зөрчил байна. Үүнд: Прокурорын ерөнхий газраас нэмэлтээр баталсан төсвөөс эд хогшил худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг дагаж мөрдөлгүй 20.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Жич: Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын 1.4-т ТБОНӨХБАҮХАТХ-ын дагуу худалдан авалтын үйл явцыг шалгаж санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэлгүй бол санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтэд нөлөөлөхгүй гэж заасны дагуу уг алдаа зөрчлийг нөлөөлөхгүй гэж үзсэн.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэж шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих нийт 149 мэдээллээс 141 мэдээллийг хугацаандаа, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байцаан шийтгэх ажиллагааны батлагдсан төсвийн зарцуулалтыг авч үзэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 23.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн алдааг залруулж, 23.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

1. Үр дүнгийн тайлангийн цалин, хөдөлмөрийн хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг 0.2 сая төгрөгөөр эдийн засгийн ангилал зөрүүлэн тайлагнасан.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Байцаан шийтгэх ажиллагааны зориулалтаар батлагдсан төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд 3.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт холбогдох хууль, тогтоомжоор заасан хэм хэмжээний хүрээнд зохицуулалт хийх, хуваарьт өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээг авч төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үнэн зөв тайлагнаж байх.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Прокурорын ерөнхий газраас нэмэлтээр баталсан төсвөөс эд хогшил худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг дагаж мөрдөлгүй 20.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйл 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 34 дүгээр зүйл 34.1 “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу төсвийг үр ашигтай, оновчтой төлөвлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Замын-Үүд сум дахь сум дундын Прокурорын газар	3	23.6	1	0.2	-	-	-	-	2	23.4
	НИЙТ	3	23.6	1	0.2					2	23.4